



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/435

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Наран тулгуур” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Төв номын сан 24 айлын орон сууцны дундах талбайн тохижилтын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Б.Ганзориг

- Мэргэжлийн хяналтын газрын авто замын
хяналтын улсын байцаагч

Б.Түмэндэмбэрэл

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

З.Өмиртай

- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын
газрын Барилга, хот байгуулалтын
хэлтсийн дарга

Б.Туулайтулга

- Жаргалант сумын Засаг даргын орлогч

Б.Болор-Эрдэнэ

- Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

С.Батдорж

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,
эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга

Г.Энхжин

- “Наран тулгуур” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн
дарга: Б.Жамбалдорж

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын мэргэжилтэн

02.2312
Zan A/435 Kh

2. “Наран тулгуур” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН